



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удиралтын орчон: 7-р бац, Сайшигаан сум  
Дундговь аймаг 48099 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgov@audit.gov.mn

2024-03-25 № 115

тавайл -ны № -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ц.ОДБАЯР ТАНАА

Өөрчлөлтийг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиостой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолжон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дун өмнөх оноос 1.2 дахин буюу 417.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд сумын Засаг даргын Тамгын газар 506.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хулээн авсантай холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайландаа толилуулсан бөгөөд санхүүгийн тайландаа толилуулаагүй асуудал гаралаагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгджөн татаан буутдаа, нэгдэх асуудал гаралаагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайландаа нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй, байгаль орчны төлөв байдлын үзэлгээ хийгдээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж баталсан, төсөл арга хэмжээг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд

хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгаагүй зэрэг зөрчил нь тайлант үсийн удирдлагын үзэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохицой нотолгоог олж авах боломжгүй нехцэл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохицой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хетелбэр, 28 зорилт, 144 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 92.2 хувийн гүйцэтгэлтэй тайллагнасан байна.

#### Санхүүгийн тайландаа төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дугиалт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийт илрүүлийн гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайландаа үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МОНХТОГОХ

